



**ЭРДЭНЭС МОНГОЛ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 22-дөр

Дугаар 131

Улаанбаатар хот

**“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын  
зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг  
шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76.1.18, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 3.2.7.4, 3.5.1, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын дүрмийн 4.1.1, 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг 1582 байхаар тогтоосугай.

3. Төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Захирал Д.Тогтохсүрэнд даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Даваадалайд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОДХҮҮ

152502020345

**“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**

